

**Петро Матад Лимитед
("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл ажиллагааны шинэчилсэн мэдээлэл**

Петро Матад Компани нь Давсан Толгой-11 цооногийг ("ДТ-11" гэх) 1,220 метрийн гүнд, Цагаанцавын доор хувирмал суурь чулуулаг хүртэл өрөмдөж дуусгасныг мэдэгдэж байна. Цооногийн геофизикийн бичиглэл, бэхэлгээний яндан суулгах, цементлэх ажлууд хийгдсэн.

ДТ-11 цооногийг ДТ-1 цооногоос урагшаа 225 метрийн зайд өрөмдсөн. 2011 оны 08 дугаар сард ДТ-11 цооногт хийсэн туршилтаар цооногийн цементийн барьцалдах чанар хангалтгүй байснаас формацийн эвдрэл үүссэн байж болзошгүйг тогтоосны дараа ДТ-1 цооногийг таглаж, битүүмжилсэн (RNS 1970N, 2011 оны 08 дугаар сарын 30, RNS 9542N, 2011 оны 09 дүгээр сарын 09-ний мэдээллүүдээс харна уу).

ДТ-11 цооногийн өрөмдлөгийн явцад 1,074 метрийн гүнээс эхлэн Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсэг буюу эртний голын хөндийн давхаргад нэвтэрсэн. 1,078.6-1,087 метрийн хооронд үйрмэг болон чөмөг дээж авсан бөгөөд 1,078-1,084 метрт дундаас сайн чанарын тосны илэрц тогтоогдсон. Чөмөг дээжин дэх тосны илэрц нь нүүрсустөрөгчийн хурц үнэртэй, бараан хүрэн өнгийн тосны толботой, бүдэгдүү алтлагаас цайвар шаргал өнгийн флюоресценцтэй, урсац нь шараас цагаан өнгөтэй.

1,134 метрээс суурь чулуулгийн дээд хэсэг буюу 1,151 метр хүртэл Доод Цагаанцавын формацийн нимгэн үед нэвтэрсэн бөгөөд эндээс нүүрсустөрөгчийн ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй.

Петрофизикийн шинжилгээгээр нийт 14.5 метрийн цэвэр тост үе тогтоогдсон. Энэхүү цэвэр тост үе нь 1,076-1,084 метр, 1,100-1,102 метр, 1,127-1,134 метрт буюу Дээд Цагаанцавын Формацийн дээд хэсгийн эртний голын хөндийн давхаргын дээд, дунд болон доод хэсгүүдэд тус тус байрласан байна.

Компанийн хагас жилийн үр дүнгийн тайланд мэдээлсэний дагуу Петро Матад компанийн 2011 оны өрөмдлөгийн ажил ДТ-11 цооногийн өрөмдлөгөөр дуусгавар болно. Өрмийн туслан гүйцэтгэгч Ди Кью И Интернэшнл компани 2012 онд өрөмдлөгийг шууд үргэжлүүлэн гүйцэтгэх боломжтойгоор өрмийн тоног төхөөрөмжүүдээ Компанийн талбайд үлдээсэн.

Петро Матад Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй хэлэхдээ "ДТ-11 цооногийн амжилттай өрөмдөж, цооногийн механик нөхцөл сайн байсан нь бидэнд ДТ-1 цооногт ялгасан Дээд Цагаанцавын дээд хэсгийг бүрэн судлах боломж олгож байна. Цооногийн туршилыг ойрын хугацаанд эхлүүлэхээр төлөвлөж байна".

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100